

**“ГТХЗНТ” УТУГ-ЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН БҮТЦИЙН НЭГЖҮҮДИЙН
11 ДҮГЭЭР САРЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТЭД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,
ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН АЖЛЫН ТОВЧ ТАЙЛАН**

2024 оны 12 дугаар сарын 02

Дугаар16

“ГТХЗНТ” УТУГ

Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго

“ГТХЗНТ” УТУГ-ын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг үндэслэн батлуулсан нэгжүүдийн сарын төлөвлөгөөний биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, цаашид анхаарч ажиллах асуудлын талаар санал зөвлөмж боловсруулах, удирдлага, ажилтнуудыг мэдээллээр хангаж, үйл ажиллагааны төлөвлөлт, гүйцэтгэл, үр дүнг нэмэгдүүлэх, хэрэгжилт хариуцлагыг сайжруулах зорилгоор хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлыг гүйцэтгэлээ.

Хяналт-шинжилгээ, үнэлгээний аргачлал

Нэгжүүдийн төлөвлөсөн ажлын гүйцэтгэлийг төлөвлөгөөнд урьдчилан тодорхойлсон шалгуур үзүүлэлт, зорилтот түвшин, хүлээгдэж буй үр дүнтэй харьцуулж хяналт-шинжилгээ, үнэлгээний журамд заасан аргачлалаар үнэлэв.

Үнэлэлт

Нэгжүүдийн сарын төлөвлөгөөнд тусгагдсан ажлын хэрэгжилтийн байдлыг хүснэгтээр үзүүлэв.

Нэгжийн нэр	Төлөвлөсөн ажил	Үүнээс						Хугацаа болоогүй	Биелэлт /хувиар/
		100%	90%	70%	50%	30%	0%		
ЗСХ	11	9	1	-	-	-	-	1	99.0%
ТНУАСХ	16	13	-	3	-	-	-	-	94.4%
ГХБАБМХ	7	7	-	-	-	-	-	-	100
Дүн	34	29	1	3	-	-	-	1	97.0

Дүгнэлт

Санал зөвлөмж

1. Нэгжүүд 11 дүгээр сард төлөвлөсөн 34 ажлаас 91 хувийг бүрэн хэрэгжүүлж ажилласан ба 9 хувийг хэрэгжүүлж дуусаагүй байна.

1/Жилийн эцсийн тайлан биелэлттэй холбогдуулан нэгж, ажилтнууд төвийн болон нэгжийн 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, сайдын албан даалгавар, сайдын болон захирлын тушаал, бусад төлөвлөгөө, баримт бичигт тусгагдсан арга хэмжээ бүрийн гүйцэтгэлийг хангаж, тоо баримттай тодорхой тайлагнах.

2. Тайлант сард ирүүлсэн хариутай албан бичгийн 90.5%-ийг шийдвэрлэсэн байна. Үүнээс албан бичгээр 16, цахимаар 3 бичигт хариу өгсөн байна.

2/Нэгж, ажилтан бүр хариуцсан ажлын чиглэлээр баримт бичгийг эмхлэн цэгцэлж, хөтлөх хэргийн нэрийн жагсаалт, байгууллагын баримт бичиг хадгалах хугацааны жагсаалтын дагуу 2024 онд хөтлөгдсөн баримт бичгийг бүрэн бүрдэлтэй архивт шилжүүлэх.

3.1 бичиг шийдвэрлэгдэх шатанд, хариу өгөх хугацаа болоогүй 4, хариу өгөөгүй 1 бичиг байна.

3/Төмөр замын тээврийн тухай хууль (шинэчилсэн найруулга)-ийг 2025.01.01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхтэй холбогдуулан энэ чиглэлээр гарсан Засгийн газрын тогтоол, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл, Зам, тээврийн сайдын тушаал, ЗТЯ, Төрийн албаны зөвлөл, ТӨБЗГ-ын зөвлөмж, чиглэлийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх.

4/Төрийн жинхэнэ албаны ерөнхий шалгалт өгөөгүй ажилтнууд 2025 оны 1 дүгээр улирлын ээлжит шалгалтад хамрагдах.

5/Хөдөлмөрийн тухай хууль тогтоомжийг "ГТХЗНТ" УТҮГ-ын хүний нөөцийн үйл ажиллагаанд мөрдөж байсан бол 2025 оноос Төрийн албаны тухай хууль тогтоомжийг мөрдөхөөр байгаа тул дараах хууль тогтоомжийг сайтар судалж, танилцах. Үүнд:

- Төрийн албаны тухай хууль
- Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль
- Авлигын эсрэг хууль
- Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль
- Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хууль
- Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль
- Захиргааны ерөнхий хууль
- Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль
- Монгол хэлний тухай хууль
- Зөрчлийн тухай хууль
- Төрийн болон албаны нууцын тухай хууль
- Цахим гарын үсгийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Төрийн хяналт шалгалтын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Шинэ сэргэлтийн бодлого
- Алсын хараа 2050
- Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого
- Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр
- Бусад хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний акт, сайдын тушаал шийдвэр.

6/Засгийн газрын 2023.08.23-ны өдрийн 301 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан "Төрийн жинхэнэ

албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам"-ын дагуу ЗГХЭГ-ын даргын 2023.10.31-ний өдрийн 98 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан "Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах аргачлал", 2 дугаар хавсралтаар баталсан "Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний загвар" болон бусад баримт бичгийг судалж танилцах, ажилтан бүр 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний төсөл боловсруулж бэлтгэх.

ТАНИЛЦСАН:

"ГТХЗНТ" УТУГ-ЫН ЗАХИРАЛ

А.БУЯННЭМЭХ

ГХБАБМХ-ИЙН ДАРГА

Ц.ОЮУНБАТ

ТНУАСХ-ИЙН ДАҮХГ

Ж.АЛИМАА

ХЯНАСАН:

ЗСХ-ИЙН ДАҮХГ

С.ЗОЛЗАЯА

БОЛОВСРУУЛСАН:

ХШҮМ

Э.ОСОРЖАМАА

Э.Осоржамаяа ху/02